

1

МОНГОЛ УЛСАД ЭДИЙН ЗАСАГ, СТАТИСТИКИЙН ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭСЭН 50 ЖИЛ

Г.Элдэв-Очир.

МУИС 1942 онд 3 факультеттэй үндсэн ангид 93, бэлтгэл ангид 57 оюутантайгаар байгуулагдсан нь нийгэм эдийн засаг, соёл шинжлэх ухааны салбаруудад ажиллах дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэн гаргах эхлэл болсон төдийгүй дээд боловсролын систем бүрэлдэн тогтох үндсийг тавьжээ.

1946 онд МУИС-ийн анхны төгсөлтөөр малын эмч, зоотехник, тоо-физикийн багшийн мэргэжлээр 35 оюутан төгссөн бол улс орны нийгэм, эдийн засаг, соёл шинжлэх ухааны салбарууд өргөжин тэлж, дээд боловсролтой мэргэжилтний хэрэгцээ улам өсч ирсэнтэй уялдан МУИС-ийн бүрэлдэхүүнд шинэ салбарууд нээгдэн төгсөгчдийн тоо жилээс жилд өссөөр байна. Үүнтэй уялдан Сайд нарын зөвлөлийн 1947 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 21-р тогтоолоор МУИС-ийн бүрэлдэхүүнд эдийн засгийн салбарыг шинээр нээх шийдвэр гарч эдийн засгийн мэргэжлээр үндэсний дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх үндэс тавигдсан бөгөөд анхны төгсөлтийг 12 оюутантай эхэлсэн нь одоогийн Эдийн засгийн сургуулийн суурь болсон түүхтэй. Энэ нь цаашид өргөжиж 1958-1959 оны хичээлийн жилээс МУИС-иас өрх тусгаарлан ЭЗДС бие даан байгуулагдсан нь эдийн засгийн салбараар мэргэжилтэн бэлтгэхэд удирдлага зохион байгуулалтын томоохон өөрчлөлт болсон.

Эдийн засгийн ухаанаар мэргэжилтэн бэлтгэх тогтолцоонд нарийн мэргэжлийн хэрэгцээ шаардлага өмнөхөөс илүүтэй тавигдаж ирсэнтэй уялдан ЭЗДС-ийн бүрэлдэхүүнд 1960-1961 оны хичээлийн жилд статистикийн мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж эхлээд анхны төгсөлтийг 1964 онд 27 оюутантайгаар хийсэн байдаг.

1960-1961 оны хичээлийн жилд статистикийн мэргэжлээр оюутан суралцуулахад мэргэжлийн удирдлагаар хангах үүднээс статистикийн тэнхим

байгуулахад анхны эрхлэгчээр МУИС-ийн хүндэт профессор Жанчивын Осор ажиллаж байсан. Ж.Осор багш бол 1947 оноос МУИС-д багшилж байсан. Эдийн засгийн ухааны анхны монгол багш нарын нэг юм. Статистикийн тэнхимд математикийн багш нар харьяалагдаж байсан бөгөөд Хүндэт профессор С.Дэнзэн, шинжлэх ухааны доктор Н.Логи, профессор Ө.Цэрэн нар математикийн багшаар ажиллаж байлаа.


Өнөөгийн байрнаас харахад Статистикийн мэргэжлээр 1060 гаруй дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэгдсэн байдлын дүр зураг хүснэгтээс харагдана.



Статистикийн мэргэжлээр анхны төгсөгчдөөс Сүхбаатар, Төв аймгийн гүйцэтгэх захиргааны дарга, Их Хурлын орлогч даргаар Ж.Гомбожав, Дорнод аймгийн гүйцэтгэх захиргааны нэгдүгээр орлогч даргаар С.Зундуй, Үндэсний Статистикийн Газрын хэлтсийн даргаар С.Долгор нар ажиллаж байсан ба өнөөдөр Ш.Сэржхүү зөвлөх мэргэжилтнээр ажиллаж байгаа болон 1965 оны төгсөгч Архангай аймгийн Өндөр-Улаан сумын дарга Г.Дамдиндорж, Төв аймгийн Эрдэнэсант сумын эдийн засагч А.Бат-Очир нар Ардын их хурлын депутатаар сонгогдож байсан болон статистикийн мэргэжлээр төгсөгчид төр нийгмийн өндөр түвшний албыг хашиж ирсэн нь өнөөдөр суралцаж байгаа болон өмнө нь төгсөгчид бидний бахархал болсоор байна.

Статистикийн мэргэжлийн нэгэн түүхэн бахархал нь Москвагийн эдийн засаг-статистикийн сургуулийн төгсөгч Дашийн Бямбасүрэн, Пунцагийн Жасрай нар Монгол Улсын ерөнхий сайдын албыг хашиж байсан нь манай мэргэжлийн нэгэн онцлог гэж боддог, энэнтэй санал нийлэх байх гэдэгт итгэлтэй байдаг.

Ийнхүү статистикийн мэргэжлээр үндэсний дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэн гаргаж эхэлсэн үеэс өнөөдрийг хүртэл өдөр, орой, эчнээ хэлбэрээр 1060 гаруй эдийн засагч-статистикч мэргэжилтэн бэлтгэн гаргасан байдлыг таван жилээр харуулахад дараах дүр харагдана.



Төгсөгчдийн тооны 5 жилийн график дүрслэлээс харвал 1964-1969, 1986-1990, 2001-2005 онуудад хамгийн олон хүн төгссөн гарсан нь тухайн мэргэжлийн захиалга, хэрэгцээ алсын зайн сургалттай уялдаатай байна.

Эдийн засагч-статистикч мэргэжлээр төгссөн манай төгсөгчдөөс мэргэжлийн нэр хүндийг өндөрт гаргаж байгаа хүмүүсээс заримыг онцлон дурьдахад Ардын их хурлын депутат, Их хурлын гишүүнээр удаа дараа сонгогдсон Ж.Гомбожав, Их Хурлын гишүүнээр удаа дараа сонгогдсон Ц.Баярсайхан, Их Хурлын харьяа ҮСХ-ны ерөнхий менежер Б.Ганбат, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн ерөнхийлөгч, шинжлэх ухааны гавьяат ажилтан, академич Б.Энхтүвшин, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын орлогч дарга Б.Эрдэнэбилэг, МУИС-ийн ЭЗС-ийн захирал Ц.Даваадорж, Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны газрын дарга доктор А.Дэмбэрэл, Б.Бадамцэцэг, Эрэл компанийн салбарын захирал Д.Чүлтэм, МУИС-ийн сургалтын албаны дарга Г.Цагаач, ЭЗС-ийн сургалтын албаны дарга Б.Болормаа, Хүн ам зүйн тэнхмийн эрхлэгч Б.Энхцэцэг болон аймаг, хотын статистикийн хэлтсийн даргаар Б.Төртогтох, Ч.Энхтуяа, О.Цэрэндулам, Самдан, Д.Эрдэнэчимэг, Ж.Эрдэнэсүрэн, Ц.Должин, Энхбаатар, Ж.Отгончулуун, Эрдэнэ нар, Дархан-Уул аймгийн Аудит компанийн захирлаар Н.Бэрцэцэг, Чингис зочид буудлын захирал Х.Отгонтуяа, Оргил төвийн дэд захирал Наранбаатар, Чоно компанийн захирал С.Төмөрчөдөр, Н.Зоригт Төрийн банкны, А.Мягмар, Ц.Балдандорж ХААН банкны салбарын захирлаар ажиллаж байгаа нь бидний бахархал, суралцагчдын ирээдүйдээ итгэх нэгэн шижим нь болж байна.

ҮСХ болон харьяа салбар нэгжүүдийн ажиллагсдын 80 гаруй хувь нь МУИС-ийг статистикийн мэргэжлээр төгсөгчид эзэлж байгаа нь мэргэжлийн шаардлага хэрэгцээтэй харьцангуй нийцэж байгаагийн нэгэн илэрхийлэл гэж үздэг.

Эдийн засагч-статистикч мэргэжлээр суралцаж төгссөн оюутнуудаас 60 гаруй оюутан онц сайн дүнтэй төгссөний дотор Д.Гомбодорж, Б.Ганбат, Б.Төртогтох,

Г.Батсуурь нар Сүхбаатарын нэрэмжит цалинтайгаар төгссөн нь оюутан залуучуудын сор, бахархал нь болж байдаг.

Статистикийн мэргэжлээр төгсөгчдийн ажлын байрны хангагдсан байдлыг сүүлийн жилүүдээр харуулах нь зохистой гэж бодоод дараах тоон үзүүлэлтийг толилуулж байна. Манай төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг сүүлийн 4 жилээр авч үзэж хүснэгтээр харуулав.

	2007	2008	2009	2010
Нийт төгсөгчид Үүнээс:	10	17	12	18
Төгссөн мэргэжлээр	1	2	-	1
Төр, захиргааны байгууллагад	-	4	1	6
Пүүс компанид бизнесийн байгууллага	6	8	7	6
Их, дээд сургууль эрдэм шинжилгээний байгууллагад	1	2	3	3
Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	2	1	1	2

Хүснэгтээс харвал сүүлийн 4 жилд төгсөгчид цөмөөрөө ажлын байраар хангагдсан нь бахархуштай амжилт юм.


- Сургалтын ажил.

Эдийн засагч-статистикч мэргэжлийн сургалтыг бакалавр, магистр, доктор гэсэн шатлалтайгаар явуулж байна.

Дээд сургуулиар бакалаврын зэрэгтэй дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэн гаргахад сургалтын ажлын мөрдлөг болгох хэрэгсэл нь тухайн мэргэжлийн сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр тодорхойлолт байдаг.

Сургалтын төлөвлөгөө нь сонгосон мэргэжлийн сургалтын үйл ажиллагааны үйл явц, түүний агуулгыг тодорхойлсон баримт бичиг мөн. Сургалтын төлөвлөгөөнд сургалтын ажлын логик холбоо, түүний дэс дараалал, үйлдвэрлэлийн дадлага, ангийн ажил, оюутны мэдлэг дүгнэх хэлбэр, хугацааг нарийн тодорхойлсон байдаг. Эдийн засагч-статистикч дээд боловсролтой мэргэжилтэн нь мэргэжлээрээ гүнзгий мэдлэгтэй, өндөр ур чадвар, хөдөлмөрийн дадлага бүхий мэргэжилтэн бэлтгэхэд дээд боловсролын стандартад нийцүүлэхийг нэн тэргүүний зорилт болгох шаардлагатай. Иймд сургалтын төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооны санал дүгнэлтийг анхааран үзэж сургалтын төлөвлөгөөг өөрчлөн боловсруулж ирсэн нь улс орны өнөөгийн хэрэгцээ шаардлагатай уялдан уян хатан хандах бодлогыг баримталсаныг харуулж байна. Ийнхүү сургалтын төлөвлөгөөг боловсруулахдаа сургалтанд кредит цаг нэвтрүүлсэн нь дээд боловсролын стандартад нийцүүлэх боломжийг бүрдүүлж байна. Дээд боловсролын стандарт ёсоор оюутан 120-128 кредит цагийг өөрөө цуглуулсан байх ёстой. Энэхүү кредит цагийг цуглуулахад заавал үзсэн байх хичээлээс гадна сонгон суралцах хичээлүүд сургалтын төлөвлөгөөнд

тусгагдсанаас өөрийн хүсэл сонирхол, эдийн засагч-статистикч мэргэжил эзэмшихэд хэрэгцээ ямар байгаад үндэслэн сонголт хийх боломжтой байдаг нь сургалтын төлөвлөгөөний уян хатан байдлын нэг илэрхийлэл мөн. Сургалтын төлөвлөгөөний кредит цагийн хуваарилалтыг бүдүүвчээр харуулав.



Эндээс үзэхэд сонгон суралцах хичээлүүд 26 кредит буюу нийт кредит цагийн 21.1 хувийг эзэлж байгаа нь оюутан тухайн мэргэжил эзэмшихэд өөрийн хүсэл сонирхлоор хичээл сонгон суралцах боломж хангалттай болохыг илтгэж байна. Сургалтын төлөвлөгөөний дотоод уялдаа нь оюутан тухайн хичээлийг үзэх дэгийг нарийн тодорхойлоход оршдог. Эдийн засагч-статистикч мэргэжил эзэмшихэд ерөнхий суурь хичээл 23.3%, мэргэжлийн суурь хичээл 40.6%, мэргэшүүлэх хичээл 30.1% эзэлж байна. Үйлдвэрлэлийн дадлагыг бүртгэл статистикийн хичээлээр 4 долоо хоног, нэгдсэн статистикийн хичээлээр 8 долоо хоног хийж байгаа ба статистикийн мэргэжил эзэмшихэд мэдээллийг хэрхэн бүрдүүлэх, мэдээлэлд шинжилгээ хийх практик дадлыг олоход чиглэгддэг.

Сургалтын ажлын гол цөм нь сургалтын төлөвлөгөө байдаг бол сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үндэс нь сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийн тодорхойлолт хөтөлбөрийг боловсруулах явдал байдаг. Хичээлийн тодорхойлолт, хөтөлбөрт тухайн хичээлээр олгох мэдлэгийг тусгах төдийгүй хичээлийг судлах дараалал өөрөөр хэлбэл, өмнө нь ямар хичээлүүдийг судалсан байх ёстойг тодорхойлсон байдаг.

- Эрдэм шинжилгээний ажил

Дээд боловсролын системийн нэг онцлог нь нийгэм эдийн засгийн эцсийн хэрэглээг хангахуйц бакалаврын зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэхэд тухайн

мэргэжил эзэмшихэд шаардлагатай шинжлэх ухааны суурь мэдлэг олгохын хамт, олсон онолын мэдлэгтээ суурилан эрдэм шинжилгээний практик ажлын зохих хэмжээний дадлага эзэмшүүлэх нь дээд боловсролын системийн үндсэн зорилгын нэгэн хэсэг мөн. Энэхүү зорилтоос үзэхэд дээд сургуулиар мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагаа нь эрдэм шинжилгээний байгууллагын бүрэлдэхүүн хэсэг гэж үзэх бүрэн үндэслэлтэй байна.

Дээд боловсролын системийн эрхэм зорилтыг хэрэгжүүлэхэд оюутан залуучуудын сургалт, хүмүүжил, эрдэм шинжилгээний ажлын чанарыг дээшлүүлж үр өгөөжийг нэмэгдүүлэх, оюутан суралцагсдын идэвхийг өрнүүлэхэд багшлах боловсон хүчний бүрэлдэхүүнийг сайжруулах, мэргэжлээр нь өсгөх, заах арга ур чадварыг дээшлүүлэх, тэднийг урамшуулан хөхүүлэн дэмжих, сургалтын материаллаг баазыг сайжруулах явдал байдаг. Энэхүү зорилтын хэрэгжилтийг авч үзвэл манай тэнхимд багшилж байсан багш нараас тэнхимийн анхны эрхлэгч МУИС-ийн хүндэт профессор Ж.Осор, докторын зэргийг Монгол улсын ерөнхий сайдаар ажиллаж байсан Монгол улсын гавьяат эдийн засагч доктор П.Жасрай, Монгол улсын гавьяат багш доктор С.Хандсүрэн, Монгол Улсын гавьяат эдийн засагч профессор Р.Ойдовданзан, төлөвлөгөө-статистикийн тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байсан Монгол улсын гавьяат эдийн засагч, шинжлэх ухааны доктор С.Нямзагд, багш нараас шинжлэх ухааны докторын зэргийг Н.Содномдорж, докторын зэргийг Ц.Цэрэндорж, Л.Дуламсүрэн, Б.Ганбат, Г.Элдэв-Очир, Ч.Даваасүрэн, Б.Энх-Амгалан, А.Солонго, Б.Болормаа, Б.Энхцэцэг нар хүртсэн нь оюутан суралцагсдыг оюуны хөрөнгө оруулалт, тэднийг эрдэмжүүлэхэд зохих хувь нэмэр оруулсан бахархууштай зүйлсийн нэг мөн. Эндээс үзэхэд манай тэнхимийн эрхэм зорилго тэнхимийн багш нарыг эрдэмжүүлэхэд анхаарал тавьдаг байдлын илэрхийлэл бахархах зүйл гэж бодож байдаг. Манай тэнхимийн багш, тэнхимийн эрхлэгчээр, Манай тэнхимийн Үндэсний Статистикийн Газрын даргаар ажиллаж байсан Ч.Даваасүрэн одоо Ази Номхон Далайн орнуудын Статистикийн Институтын захирлаар ажиллаж байгаа нь тэнхимийн нэр хүндэд үнэтэй хувь нэмэр оруулж байна.

Үндэсний Статистикийн Хороотой хамтын ажиллагааны гэрээтэй ажиллаж сургалт, эрдэм шинжилгээний материаллаг баазыг бэхжүүлэхэд гүн туслалцаа үзүүлж байдгийн зэрэгцээ тус газрын өндөр мэдлэг ур чадвар бүхий хүмүүс манай сургуульд хичээл зааж, үйлдвэрлэлийн дадлагыг удирдаж байгаа нь сургалтын онол практикийн уялдааг сайжруулах төдийгүй эрдэм шинжилгээний ажлын практик дадлыг олох боломжийг бүрдүүлж байдаг. Үндэсний Статистикийн Хороотой хамтран ажиллах гэрээний хүрээнд тэнхимийн багш нараас Үндэсний Статистикийн Хороон дээр зохион байгуулагдаж байгаа хурал, зөвөлгөөн, семинарт оролцуулж байгаа нь багш нарын мэргэжил дээшлүүлэх хэлбэрийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг болж байгаа нь сургалтын ажлын онол практикийн уялдааг сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулж байгаа бөгөөд энэ хэлбэрийг улам гүнзгийрүүлж боловсронгуй болгоно гэдэгт бид найдаж байдаг.

Дээд боловсролын системийн нэгэн онцлог бол сургалт, эрдэм шинжилгээний ажлын нэгдэл байдаг бөгөөд тухайн улс орны эрдэм шинжилгээний ажлын чадавхийг нэмэгдүүлэх нөхцөл болдог байдлыг товчхон харуулахыг хичээв.